

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Оюуны өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхтуул Утас: 261628 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn Б энд С аудит ХХК-ийн захирал: Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/307
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Оюуны өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Оюуны өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 149,072.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн байх зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Газрын даргын 2023 оны А/165 дугаар тушаалаар бүх ажилтан албан хаагчдад ажилсан жил, ажлын үр дүнг дүгнэлгүй 95,500.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан, олгосон;
- Оны эцэст 3 байгууллагатай сурталчилгаа хийлгэх зорилгоор тус бүр 7,400.0 мянган төгрөгийн гэрээ хийж нэг өдрийн зайтай 2 хувааж төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэн шилжүүлж, жилийн эцсээр гэрээг дүгнээгүй, нийт 22,200.0 мянган төгрөгийн шилжүүлсэн;
- Үйл ажиллагааны орлого төвлөрүүлдэг арилжааны банкны данснаас 15,687.2 мянган төгрөгийн зардал гаргаж, жилийн эцэст нэр данс зөрүү 300015 дансанд бичилт хийж, буцаан тушаасан боловч тус зардлыг гаргах тушаал, шийдвэр байхгүй;

- Газрын даргын 2022 оны А/88 дугаар тушаалаар албан хаагчдад олгох унааны хөнгөлөлтийг өдөрт 2000 төгрөг болгож, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолыг мөрдөөгүй, нийт 15,685.5 мянган төгрөгийг олгосон.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; 15.1.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1-т “Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны хүрээнд төсвийн байгууллага бүр бүртгэлийн данстай байна. Төрийн сан нь төсвийн байгууллагын батлагдсан төсвийн хуваарийн дагуу орлого, зарлагын гүйлгээ, төлбөр тооцоог Төрийн сангийн нэгдсэн дансаар хийж гүйцэтгэнэ”, 7.11-т “Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө”, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2-т “Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АНУ-ын Патент, барааны тэмдгийн газартай хамтын ажиллагааны инновац, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оюуны өмчийн гүйцэтгэх үүрэг, оюуны өмчийг эзэмших, ашиглах, хамгаалахад чиглэсэн уулзалт, сургалт, семинар зохион байгуулах, оюуны өмчийг олон нийтэд сурталчлах, патент, барааны тэмдгийн шинжээчдийг сургах, харилцан туршлага, мэдээлэл солилцох зэргээр талууд ирэх таван жилийн хугацаанд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна.

Аудитын гол асуудал

Албаны хэрэгцээнд ашиглаж буй программ хангамжийг лицензжүүлэх ажлын хүрээнд Газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хороо нь албаны хэрэгцээнд ашиглаж буй программ хангамжийг лицензжүүлэх судалгааг хийж, техникийн даалгаврыг боловсруулж, албаны компьютеруудад 85,000.0 мянган төгрөгийн MS Office 365 хувилбар 50, Antivirus программ хангамж тус тус 20 ширхгийг авч 100% лицензжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 95.3 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	462,828,428.04	236,165,660.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,688,811.00	33,677,908.00
311	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
312	Банканд байгаа бэлэн мөнгө	84,688,811.00	33,677,908.00
3121	Төгрөг	84,688,811.00	33,677,908.00
31211	Төрийн сангийн харилцах	84,688,811.00	33,677,908.00
33	АВЛАГА	-	711,071.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		711,071.00
34	УРЬДЧИЛГАА	287,371,400.00	80,260,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	287,371,400.00	80,260,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,768,217.04	121,516,681.04
351	Түүхий эд материал	25,938,944.00	17,707,414.00
35110	Тусгай зориулалттай материал	17,733,225.00	11,041,695.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,205,719.00	6,665,719.00
354	Хангамжийн материал	64,829,273.04	103,809,267.04
35410	Бичиг хэргийн материал	5,323,908.00	8,389,450.00
35420	Аж ахуйн материал	23,732,885.04	27,753,834.04
35430	Сэлбэг хэрэгсэл	3,709,000.00	2,884,000.00
35440	Түлш, шатах тослох материал	180,000.00	3,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	31,883,480.00	61,281,983.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	867,752,878.84	991,786,525.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	867,752,878.84	991,786,525.72
392	Биет хөрөнгө	769,440,661.42	935,731,983.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	177,400,000.00	158,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(124,140,833.47)	(113,230,833.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,405,412,095.00	1,757,355,794.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(793,871,895.99)	(953,946,451.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,342,933.00	177,342,933.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,701,637.12)	(90,189,459.36)
393	Биет бус хөрөнгө	98,312,217.42	56,054,542.50
39301	Программ хангамж	187,624,009.00	187,624,009.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(89,311,791.58)	(131,569,466.50)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,330,581,306.88	1,227,952,185.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	8,225,338.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,225,338.00
413	Өглөг	-	8,225,338.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		8,225,338.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,330,581,306.88	1,219,726,847.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,330,581,306.88	1,219,726,847.76
512	Хуримтлагдсан үр дүн	1,330,581,306.88	1,219,726,847.76
51210	Өмнөх үеийн үр дүн	1,330,581,306.88	1,320,881,306.88
51220	Тайлант үеийн үр дүн		(110,854,459.12)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,330,581,306.88	1,227,952,185.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>1,947,013,600.40</u>	<u>2,676,574,490.75</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,830,842,504.30	2,191,489,190.75
120	Нийтлэг татварын бус орлого	1,830,842,504.30	2,191,489,190.75
120003	Торгуулийн орлого	60,653,131.00	69,354,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,742,284,612.09	2,122,104,490.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,741,949,851.09	2,122,104,490.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	334,761.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	27,570,000.21	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		30,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,171,096.10	485,085,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,730,096.10	475,255,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,730,096.10	475,255,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,441,000.00	9,830,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,441,000.00	9,830,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>1,586,597,525.65</u>	<u>2,509,817,549.87</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,586,597,525.65	2,509,817,549.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,573,384,325.65	2,231,288,995.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,550,771.00	1,240,486,331.65
210101	Үндсэн цалин	484,322,458.00	758,419,570.57
210102	Нэмэгдэл	121,954,594.00	255,768,168.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	92,651,543.00	139,938,711.04
210104	Урамшуулал	53,622,176.00	86,359,882.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,903,995.58	157,761,548.18
210201	Тэтгэврийн даатгал	64,680,956.66	109,914,140.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,588,995.32	12,376,470.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,010,715.67	9,943,807.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,420,302.35	2,320,099.74
210205	Эрүүл мэндийн даатгал	14,203,025.58	23,207,030.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,536,900.00	321,865,286.82
210301	Гэрэл, цахилгаан	39,301,200.00	58,988,978.00
210302	Түлш, халаалт	26,896,300.00	28,553,220.76
210303	Цэвэр, бохир ус	47,641,000.00	54,671,088.06
210304	Байрны түрээс	178,698,400.00	179,652,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,496,348.61	65,195,079.53
210401	Бичиг хэрэг	9,921,858.00	14,830,458.00
210402	Тээвэр, шатахуун	11,265,176.00	180,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,972,792.61	28,648,316.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,608,000.00	2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,728,522.00	18,716,305.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,616,935.00	37,988,800.00
210604	Урсгал засвар	20,616,935.00	37,988,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,089,800.00	7,171,033.00
210702	Дотоод албан томилолт	3,089,800.00	7,171,033.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,961,953.00	119,669,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,281,827.00	107,683,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,600.00	

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,306.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,180,000.00	5,265,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,304,220.00	6,721,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,227,622.46	281,151,046.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		31,546,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,475,402.00	21,694,294.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	220,752,220.46	227,910,052.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,213,200.00	278,528,554.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,772,200.00	132,987,257.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,772,200.00	8,599,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		32,388,257.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		92,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,441,000.00	16,950,356.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,120,356.17
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/	4,441,000.00	9,830,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	128,590,941.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		128,590,941.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	360,416,074.75	166,756,940.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,566,666.55	277,611,400.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	51,566,666.55	277,611,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(51,566,666.55)	(277,611,400.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	308,849,408.20	(110,854,459.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,918,774,078.19	2,684,769,828.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,802,602,982.09	2,199,684,528.75
120	Нийтлэг татварын бус орлого	60,653,131.00	69,354,700.00
120003	Торгуулийн орлого	60,653,131.00	69,354,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,741,949,851.09	2,122,104,490.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,741,949,851.09	2,122,104,490.75
120009	Бусад орлого		8,225,338.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,171,096.10	485,085,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,730,096.10	475,255,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,730,096.10	475,255,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,441,000.00	9,830,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,441,000.00	9,830,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,676,350,862.19	2,383,837,032.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,676,350,862.19	2,383,837,032.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,663,137,662.19	2,105,308,478.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,550,771.00	1,241,027,082.65
210101	Үндсэн цалин	484,322,458.00	758,960,321.57
210102	Нэмэгдэл	121,954,594.00	255,768,168.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	92,651,543.00	139,938,711.04
210104	Урамшуулал	53,622,176.00	86,359,882.00
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	93,903,995.58	157,931,868.18
210201	Тэтгэврийн даатгал	64,680,956.66	110,084,460.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,588,995.32	12,376,470.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,010,715.67	9,943,807.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,420,302.35	2,320,099.74
210205	Эрүүл мэндийн даатгал	14,203,025.58	23,207,030.14
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	292,536,900.00	321,865,286.82

210301	Гэрэл, цахилгаан	39,301,200.00	58,988,978.00
210302	Түлш, халаалт	26,896,300.00	28,553,220.76
210303	Цэвэр, бохир ус	47,641,000.00	54,671,088.06
210304	Байрны түрээс	178,698,400.00	179,652,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,435,865.61	61,431,673.53
210401	Бичиг хэрэг	7,635,350.00	18,365,800.00
210402	Тээвэр, шатахуун	7,019,300.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,972,792.61	28,648,316.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	1,608,000.00	2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,200,423.00	8,097,557.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	163,481,415.00	65,181,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	138,805,700.00	
210604	Урсгал засвар	24,675,715.00	65,181,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,089,800.00	7,171,033.00
210702	Дотоод албан томилолт	3,089,800.00	7,171,033.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	282,498,513.00	217,091,340.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,647,607.00	172,463,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,600.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,306.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,655,000.00	44,628,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,000,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,640,402.00	33,608,994.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,914,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,640,402.00	21,694,294.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,213,200.00	278,528,554.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,772,200.00	132,987,257.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,772,200.00	8,599,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		32,388,257.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		92,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,441,000.00	16,950,356.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,120,356.17
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/	4,441,000.00	9,830,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	128,590,941.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		128,590,941.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	242,423,216.00	300,932,796.40
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	181,770,085.00	351,943,699.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,770,085.00	351,943,699.40
2200	Дотоод эх үүсвэрээр	181,770,085.00	351,943,699.40
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	181,770,085.00	351,943,699.40
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(181,770,085.00)	(351,943,699.40)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	60,653,131.00	(51,010,903.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,035,680.00	84,688,811.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,688,811.00	33,677,908.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00		1,022,066,659.68	1,022,066,659.68
C02	Тайлант үеийн үр дүн			308,514,647.20	308,514,647.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,330,581,306.88	1,330,581,306.88
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,330,581,306.88	1,330,581,306.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,330,581,306.88	1,330,581,306.88
D08	Тайлант үеийн үр дүн			(110,854,459.12)	(110,854,459.12)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,219,726,847.76	1,219,726,847.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,707,395,800.0	2,590,239,434.6	117,156,365.4	95.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,707,395,800.0	2,590,239,434.6	117,156,365.4	95.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,572,102,300.0	2,457,252,177.6	114,850,122.4	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,264,429,300.0	1,241,027,082.7	23,402,217.3	98.1
210101	Үндсэн цалин	712,023,300.0	758,960,321.6	(46,937,021.6)	106.6
210102	Нэмэгдэл	291,975,200.0	255,768,168.0	36,207,032.0	87.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,760,000.0	139,938,711.0	(4,178,711.0)	103.1
210104	Урамшуулал	124,670,800.0	86,359,882.0	38,310,918.0	69.3
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	170,554,100.0	157,931,868.2	12,622,231.8	92.6
210201	Тэтгэврийн даатгал	112,776,700.0	110,084,460.5	2,692,239.6	97.6
210202	Тэтгэмжийн даатгал	14,444,400.0	12,376,470.5	2,067,929.5	85.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,555,400.0	9,943,807.3	1,611,592.7	86.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,888,900.0	2,320,099.7	568,800.3	80.3
210205	Эрүүл мэндийн даатгал	28,888,700.0	23,207,030.1	5,681,669.9	80.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,522,500.0	321,865,286.8	15,657,213.2	95.4
210301	Гэрэл, цахилгаан	61,318,300.0	58,988,978.0	2,329,322.0	96.2
210302	Түлш, халаалт	37,837,800.0	28,553,220.8	9,284,579.2	75.5

210303	Цэвэр, бохир ус	58,714,400.0	54,671,088.1	4,043,311.9	93.1
210304	Байрны түрээс	179,652,000.0	179,652,000.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	66,637,400.0	61,431,673.5	5,205,726.5	92.2
210401	Бичиг хэрэг	18,550,000.0	18,365,800.0	184,200.0	99.0
210402	Тээвэр, шатахуун	3,527,200.0	3,500,000.0	27,200.0	99.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,120,000.0	28,648,316.5	4,471,683.5	86.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,024,700.0	2,820,000.0	204,700.0	93.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,415,500.0	8,097,557.0	317,943.0	96.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	394,532,000.0	379,581,899.4	14,950,100.6	96.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	324,000,000.0	314,400,699.4	9,599,300.6	97.0
210604	Урсгал засвар	70,532,000.0	65,181,200.0	5,350,800.0	92.4
2107	Томилолт, зочны зардал	14,143,900.0	7,171,033.0	6,972,867.0	50.7
210702	Дотоод албан томилолт	14,143,900.0	7,171,033.0	6,972,867.0	50.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	282,586,900.0	254,634,340.0	27,952,560.0	90.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,930,900.0	172,463,340.0	16,467,560.0	91.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	89,076,000.0	82,171,000.0	6,905,000.0	92.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,580,000.0		4,580,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,696,200.0	33,608,994.0	8,087,206.0	80.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,700,000.0	11,914,700.0	785,300.0	93.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,996,200.0	21,694,294.0	7,301,906.0	74.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,293,500.0	132,987,257.0	2,306,243.0	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,293,500.0	132,987,257.0	2,306,243.0	98.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,897,600.0	8,599,000.0	1,298,600.0	86.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,395,900.0	32,388,257.0	1,007,643.0	97.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,000,000.0	92,000,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,707,395,800.0	2,590,239,434.6	117,156,365.4	95.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	475,255,300.0	468,134,943.8	7,120,356.2	98.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	475,255,300.0	468,134,943.8	7,120,356.2	98.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,232,140,500.0	2,122,104,490.8	110,036,009.3	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,232,140,500.0	2,122,104,490.8	110,036,009.3	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	84,688,811.0		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,677,908.0		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59	47	12	79.7
620001	Удирдах ажилтан	5	5	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	54	42	12	77.8

Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 496,220.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 9,700.0 мянган төгрөгийг залруулж, 470,834.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 15,685.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Оюуны өмчийн газар	1	9.7			1	9.7	1	9.7				
Дүн	1	9.7			1	9.7	1	9.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Оюуны өмчийн газар	5	149.1			3	133.4	2	15.7				
Дүн	5	149.1			3	133.4	2	15.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Оюуны өмчийн газар	1	337.4					1	337.4	
Дүн	1	337.4					1	337.4	